



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/90

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8, Батлан хамгаалахын сайдын Хэнтий аймийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 5.1, Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрхаан суман дахь Зэвсэгт хүчний 232 дугаар ангитай хамтран ажиллах, бие бүрэлдэхүүний албан үүргээ гүйцэтгэх нөхцлийг хангахад 1200000 /нэг сая хоёр зуун мянган/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Цугларалт, бэлтгэл сургууль, дайчилгаа, түр цэрэг зардлаас санхүүжүүлж, зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, хяналт тавьж ажиллахыг Цэргийн штаб /дэд хурандаа Н.Хүрэлээ/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА